

## **Ж.Цогтсанаа: Үндэсний брэнд карт гарахаас өмнө 1000 төгрөг тутмын 20-ыг нь гадагшаа алдаж байсан**

Х.Түвшинтөгс

Монголбанк Үндэсний брэнд карт гаргаснаа олон нийтэд албан ёсоор танилцууллаа. Тус банкны Цахим үйлчилгээний төвөөс өнгөрсөн онд арилжааны банкуудтай хамтарч “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г байгуулсан бол энэ онд Үндэсний брэнд “Т” картыг гаргаж байгаа юм байна. Ингэснээр “Visa”, “Master” зэрэг гадаадын картыг зах зээлээс шахагдаж, дотоодын брэнд картын үйлчилгээ зах зээлд ноёрхох алхам тавигджээ. Үүний эхлэл болгож “Худалдаа хөгжлийн банк”-ны гүйцэтгэх захирал Б.Мэдрээ брэнд карт гаргах эрхийн батламжыг Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Золжаргалаас өчигдөр гардаж авлаа. Энэхүү брэнд картын түрүүч ирэх дөрөвдүгээр сараас хэрэглэгчдийн гар дээр очих аж. Энэ талаар Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн захирал Ж.Цогтсанаатай ярилцлаа.

**-Үндэсний брэнд картын нэг онцлог нь төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх боломжийг бүрдүүлж байгаа юм байна. Тийм үү?**

-Тэгж ойлгож болно. Энэ тал дээр төрийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Бид Иргэний бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Сангийн яамны холбогдох хүмүүстэй нь яриа, хэлэлцээрээ хийгээд эхэлчихсэн л дээ. Гэхдээ Монголбанк, арилжааны банкууд болон төрийн албаныхны хооронд ойлголцох, тайлбарлах зүйлүүд их байна. Энэ бүх ажлыг цэгцэлж, тодорхой шат дарааллаар нь үргэлжлүүлээд хийнэ. Бид эхний ээлжид брэнд картаа гаргахыг зорьсон. Энэ зорилгодоо ч хүрлээ. Одоо дараагийн асуудлууд үлдлээ.

**-Жишээ нь, төрийн ямар үйлчилгээг Үндэсний брэнд картаар үзүүлэх боломжтой вэ?**

-Жишээлбэл, Монголбанк ЦЕГ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна. Эхний ээлжинд бид иргэдийн ЦЕГ-аас авдаг лавлагааны төлбөрийг тооцоог “Т” картаар хийж болох юм гэсэн шийдэлд хүрээд байгаа. Мөн замын цагдаа болон эргүүлийн цагдаа нар иргэдийн гаргасан зөрчилд ногдуулдаг торгуулийг ч гэсэн картаар төлж болох юм. Цаашдаа гааль, цагдаагийн байгууллагаас иргэдэд бэлэн мөнгөөр үзүүлдэг бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхийг зорьж байгаа.

**-Тэгэхээр төрийн албадыг карт уншигчаар хангах асуудал босч ирэх нь ээ?**

-Янз бүрийн шийдэл байж болно л доо. Сангийн яам, Монголбанк болон төрийн зарим албатай хамтарсан ажлын хэсэг тодорхой шийдэлд хүрэхээр ажиллаж байгаа.

**-Хүний хөгжил сангийн мөнгийг “Т” картаар тараана гэж ярьж байсан.**

-Ер нь бол төрийн бүх үйлчилгээг “Т” картаар үзүүлдэг болгох чиглэлийг Монголбанкнаас баримталж байгаа. Тэгэхээр дан ганц Хүний хөгжил сангийн мөнгө ч гэлтгүй аливаа тэтгэвэр, тэтгэмжийг бэлэн бус хэлбэрээр иргэдийн гарт хүргэхийг зорино.

**-Иргэд Тавантолгойн хувьцаа эзэмшиж эхэлсэн. Хувьцааны ногдол ашиг тарааж эхэлбэл энэхүү картаар түгээх талаар Сангийн яамтай ярилцсан уу?**

-Иргэдэд Тавантолгойн хувьцаа эзэмших данс гэж байгаа. Энэ данстайгаа картынхаа дансыг холбуулбал хувьцааны ногдол ашгийг картандаа авч болно. Мөн Хүний хөгжил сангийн мөнгийг ч гэсэн картаараа авч болно шүү дээ. Гол нь нэрийн данстайгаа л холбуулчих хэрэгтэй. Ингэсэн тохиолдолд дурын банкны дурын салбараасаа мөнгөө авч болно.

**-Монголбанк Үндэсний брэнд карт гаргаснаар зах зээлд ямар нэг байдлаар монополь байдал тогтоож байгаа хэрэг биш үү. Картын зах зээл өрсөлдөөнгүй болох юм биш биз?**

-Нэгдүгээрт, Монголбанк Үндэсний брэнд картыг зах зээлд нийлүүлэхгүй, иргэдэд тараахгүй. Бид зөвхөн стандарт, бодлогыг нь барина. Харин “Т” картыг зах зээлд нийлүүлэх эрхийг нь арилжааны банкуудад олгох юм. Одоогийн байдлаар Худалдаа хөгжлийн банк энэ эрхээ аваад байна. Дараа нь ХААН, ХАС банк карт гаргах эрхээ авахаар хүлээж байгаа. Хоёрдугаарт, монополь байдал үүсэхгүй гэж үзэж байгаа. Учир нь, арилжааны банкуудын хооронд өрсөлдөөн байх нь ойлгомжтой. Цаашилбал, Үндэсний брэнд карт “Visa”, “Master” зэрэг гадаадын картуудтай дотоодын болон гадаадын зах зээлд өрсөлдөх нь тодорхой. Гэхдээ дотоодын зах зээлд “Т” картыг давамгайлна гэсэн тооцоо бидэнд бий.

**-Яагаад дотоодын зах зээлд давамгайлна гэж?**

-Манай арилжааны банкууд гадаадын төлбөрийн картыг дотооддоо ашиглахдаа тодорхой хэмжээний татварыг гадагшаа төлдөг. Тухайлбал, гаргах эрхийн төлбөр, гүйлгээ, тайлан, тооцоо гэх зэргээр үйлдэл бүртээ татвар, шимтгэл төлдөг. Нэг жишээ хэлэхэд, “Visa”, “Master” картаар хийсэн төлбөр тооцооны 0.2 хувийг гадагшаа шимтгэл хэлбэрээр төлдөг. Өөрөөр хэлбэл, та 1000 төгрөгөөр талх худалдаж авлаа гэхэд 20 төгрөгийг нь бид гадагш нь алдаж байна гэсэн үг. Тиймээс Үндэсний брэнд карт энэ мөнгийг дотооддоо авч үлдэх давуу талтай. Мөн

олон төрлийн татвар, шимтгэлээс чөлөөлөгдөнө. Эдгээр нь Үндэсний брэнд картын давуу тал болох юм.

**-Карт ашигласны шимтгэл хэдэн төгрөг байх бол?**

-Монголбанк энэ удаа карт ашигласны шимтгэлийн асуудалд оролцохгүй. Өөрөөр хэлбэл, арилжааны банкууд өөрсдөө шийднэ. Ер нь бол өмнө нь гадаадад төлдөг байсан төлбөр тооцоо нь хасагдаад ирэхээр зардал нь ч өөрөө багасаад ирнэ л дээ. Эндээс гарсан хэмнэлтээр арилжааны банкууд мөнгөний машин, карт уншигчийнхаа тоог нэмэгдүүлнэ гэж найдаж байгаа.

**-Мөнгөний машин, карт уншигчийн тоо нэмэгдсэнээр ямар үр ашиг гарах вэ?**

-Өнгөрсөн онд нийт 3.5 их наяд төгрөгийн гүйлгээг картаар хийсэн гэсэн тооцоо гарсан байна лээ. Гэхдээ үүний 80 хувь нь буюу 2.5 их наяд нь “АТМ” буюу бэлэн мөнгөний машинаас авсан мөнгөний гүйлгээ эзэлж байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ гэхээр хүмүүс цалингаа картандаа хийлгэсэн ч бэлэн мөнгөний машинаас мөнгөө аваад дэлгүүр, зах руу явж байна гэсэн үг. Тиймээс бид энэ мөнгөний урсгалыг картаар хийлгэхийн тулд дэлгүүр, хүнсний захуудад карт уншигч байрлуулах бодлого барьж байгаа юм. Ингэснээр бэлэн бус төлбөр тооцооны хувь хэмжээ нэмэгдэнэ. Түүнчлэн далд эдийн засаг ил гарч, татвараас зугтах байдал ч гэсэн тодорхой хэмжээгээр хумигдана.

**-Үндэсний брэнд картын хэлбэр хэмжээ, дизайн ямар байх вэ?**

-Үндэсний брэнд картын нэр, лого загварын стандартыг баталсан байгаа. Бид өнөөдөр /өчигдөр/ олон нийтэд “Т” картынхаа загварыг албан ёсоор олон нийтэд танилцууллаа. Цаашдаа энэ стандартынхаа дагуу хэвлэгдэнэ.